



**ЦУС СЭЛБЭЛТ СУДЛАЛЫН
ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЗАХИРЛЫН
ТУШААЛ**

2022 оны 09 сарын 06 өдөр

Дугаар А/54

Улаанбаатар хот

Дотоод аудит зохион байгуулах тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.6 дахь заалт, Монгол улсын Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоол, Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо /MNS OHSAS 18001:2012/, Эрүүл мэндийн лаборатори-Чанар ба чадавхид тавих шаардлага /MNS ISO 15189:2015/ үндэсний стандарт, Үндэсний төвийн “Дотоод аудит зохион байгуулах журам”-ыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нэгдсэн лабораторийн тасгийн MNS ISO 15189:2015 стандартын хэрэгжилтэнд Дотоод аудит хийх төлөвлөгөөг 1, дотоод аудитын Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Дотоод аудит хийхтэй холбогдуулан бэлтгэл ажил ханган хамтран ажиллахыг Нэгдсэн лабораторийн тасгийн эрхлэгч /М.Цэрэндэжид/-д үүрэг болгосугай.

3. Дотоод аудитын үнэлгээний дүн, тайланг Удирдлагын зөвлөлд танилцуулан, зохих арга хэмжээ авч ажиллахыг Ажлын хэсгийн ахлагч /М.Цэрэндэжид/-д даалгасугай.


4. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, маркетингийн албаны дарга /Ч.Батболд/-д үүрэг болгосугай.

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ



Н.ЭРДЭНЭБАЯР

ЦССҮТ-ийн Ерөнхий захирлын
2022 оны 12 дүгээр сарын 05 өдрийн
1154 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт



**Нэгдсэн лабораторийн тасагт MNS ISO 15189:2015 стандартын
хэрэгжилтэнд аудит хийх төлөвлөгөө**

| № | Үйл ажиллагаа | Хугацаа | Хариуцах эзэн | Үр дүн |
|----|---|--------------|--|--|
| 1. | Аудитын багийн ахлагч, гишүүдийг сонгож тушаал гаргах | 2022.09.07 | М.Цэрэндэжид | Аудитийн баг бүрдэнэ. |
| 2. | Аудитын багийн ахлагч гишүүдэд аудит явуулах чиглэл өгөх | 2022 .09. 08 | М.Цэрэндэжид Чанарын менежер, халдвар судлаач эмч | 3 үндсэн нэгжид аудит явуулна. • Иммуногематологийн нэгж • Халдвар илрүүлэх нэгж • Бүтээгдэхүүний чанарын хяналтын нэгж |
| 3. | Аудит хийх үнэлгээний маягт ба шалгах хуудас (MNS ISO/IEC 15189:2015 дээр суурилсан)-тай танилцах | 2022 .09. 08 | Аудитын багийн гишүүд | Аудитын багийн гишүүд аудит явуулах шалгууртай танилцсан байна. |
| 4. | Аудит хийх мэдээллийг хүргүүлж, тов тогтоох | 2022 .09. 08 | Аудитын багийн гишүүд | Тасаг нэгж аудитад бэлтгэнэ |
| 5. | Баг тус бүр аудитын өмнөх уулзалт зохион байгуулах | 2022 .09. 09 | Аудитын багийн гишүүд | Нийт ажиллагсад ойлголт авах |
| 6. | Тайлан бичих | 2022 .09. 12 | Аудитын багийн гишүүд | |
| 7. | Хаалтын хурал | 2022 .09. 12 | | Зөвлөмж, тайлан хүргүүлэх, үл тохирол илэрсэн бол залруулах хугацаа өгөх |
| 8. | Үл тохирлыг хаалгах | 2022 .10. 12 | Тасгийн эрхлэгч | Тасгийн үйл ажиллагаа сайжирна. |

ЦССҮТ-ийн Ерөнхий захирлын
2022 оны 09 дүгээр сарын 06 өдрийн
459 дугаар тушаалын 2 дугаар хавсралт

Дотоод аудит хийх Ажлын хэсгийн бүрэлдэхүүн № 9126905

Ахлагч : А.Амарзаяа -Цусны чанар, аюулгүй байдлын албаны дарга

Гишүүд: Д. Туул -Нэгдсэн лабораторийн тасгийн Лабораторийн их
эмч

Э. Чагцалдулам –Цусны чанар, аюулгүй байдлын албаны
Чанарын менежер, халдвар судлаач эмч

Нарийн бичгийн дарга: Н.Баяртогтох,- Нэгдсэн лабораторийн тасгийн
чанарын менежер